БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2025/164/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2026 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: С.Нурлан<br>Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
Асуудлыг Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. хэсэг . **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал ..... **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 12
4.1 Ерөнхий зүйл ..... 12
4.2 Материаллаг байдал ..... 12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 13
5.1 Төлбөрийн акт ..... 13
5.2 Албан шаардлага ..... 14
5.3 Зөвлөмж ..... 15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРА Ж.КҮЛДАН ТАНАА

20260213 № 62

танай ____________ -ны № ____________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цэнгэл сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 1,652.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,616.5 сая төгрөг зарцуулж, 95.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

83700500009

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **109,502,013.47** | **16,181,249.36** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 105,801,213.47 | 12,506,247.36 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 105,801,213.47 | 12,506,247.36 |
| **3121** | **Төгрөг** | 105,801,213.47 | 12,506,247.36 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 105,801,213.47 | 12,506,247.36 |
| **33** | **АВЛАГА** | - | 632,002.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 632,002.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 3,700,800.00 | 3,043,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 3,700,800.00 | 3,043,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 58,400.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 860,900.00 | 1,896,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,121,500.00 | 337,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 660,000.00 | 810,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,420,821,256.01** | **1,442,212,466.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,420,821,256.01 | 1,442,212,466.18 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,418,281,178.93 | 1,434,675,551.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,224,400,000.00 | 1,230,074,345.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,726,805.56) | (22,490,067.71) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 131,231,990.00 | 169,443,808.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (6,899,366.83) | (33,516,643.99) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 65,210,115.00 | 77,926,515.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,340,426.69) | (15,668,078.47) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 19,800,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (2,970,000.00) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | 11,405,673.01 | 12,075,673.01 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2,540,077.08 | 7,536,915.16 |
| 39301 | Програм хангамж | 2,743,239.00 | 2,743,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (203,161.92) | (406,323.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 5,200,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,530,323,269.48** | **1,458,393,715.54** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **14,048,000.00** | **3,206,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 14,048,000.00 | 3,206,000.00 |
| **413** | **Өглөг** | 14,048,000.00 | 3,206,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 14,048,000.00 | 3,206,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,048,000.00 | 3,206,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,516,275,269.48** | **1,455,187,715.54** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,516,275,269.48 | 1,455,187,715.54 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 5,200,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | - | 5,200,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,516,275,269.48 | 1,383,700,161.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,516,275,269.48 | 1,449,987,715.54 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (66,287,553.94) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,530,323,269.48** | **1,458,393,715.54** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,639,950,078.01** | **1,579,844,363.18** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,239,700.00** | **56,596,163.18** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,239,700.00 | 56,596,163.18 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,074,700.00 | 56,596,163.18 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,414,700.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 660,000.00 | 56,596,163.18 |
| 120009 | Бусад орлого | 165,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,637,710,378.01** | **1,523,248,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,599,327,878.01 | 1,466,333,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,274,455,400.00 | 1,466,333,200.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 1,324,872,478.01 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 335,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 335,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,382,500.00 | 56,580,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,382,500.00 | 56,580,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,216,400,779.20** | **1,646,131,917.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,216,400,779.20** | **1,646,131,917.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,176,757,279.10 | 1,588,208,866.12 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 919,937,456.00 | 1,256,951,972.00 |
| 210101 | Үндсэн цалин | 749,780,798.00 | 741,443,795.00 |
| 210102 | Нэмэгдэл | 137,097,027.00 | 412,237,551.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 40,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,059,631.00 | 62,495,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 123,227,800.00 | 157,819,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,794,800.00 | 107,317,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,858,200.00 | 12,625,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,929,200.00 | 6,312,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,929,200.00 | 6,312,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,716,400.00 | 25,251,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,971,999.90 | 56,879,809.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,212,587.90 | 2,016,721.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,606,912.00 | 23,705,088.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 2,358,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 36,152,500.00 | 28,800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,051,895.53 | 21,441,099.18 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 19,051,895.53 | 21,441,099.18 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 52,068,127.67 | 95,116,085.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,279,100.00 | 26,073,032.93 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,175,300.00 | 8,161,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,613,727.67 | 60,881,353.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,643,500.10 | 57,923,051.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,443,000.00 | 57,922,860.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,244,700.00 | 57,922,860.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,198,300.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 200,500.10 | 191.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200,500.10 | 191.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,423,549,298.81** | **(66,287,553.94)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,423,549,298.81** | **(66,287,553.94)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,314,417,600.00** | **1,523,248,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,579,700.00** | **335,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,579,700.00 | 335,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,414,700.00 | 335,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,414,700.00 | 335,000.00 |
| 120009 | Бусад орлого | 165,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,312,837,900.00** | **1,522,913,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,274,455,400.00 | 1,466,333,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,274,455,400.00 | 1,466,333,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,382,500.00 | 56,580,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,382,500.00 | 56,580,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,206,513,251.53** | **1,596,066,766.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,206,513,251.53** | **1,596,066,766.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,164,748,251.43** | **1,543,134,215.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 919,937,456.00 | 1,257,583,974.00 |
| 210101 | Үндсэн цалин | 614,798,059.00 | 742,075,797.00 |
| 210102 | Нэмэгдэл | 272,079,766.00 | 412,237,551.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 40,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,059,631.00 | 62,495,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 123,227,800.00 | 157,819,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 83,794,800.00 | 107,317,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,858,200.00 | 12,625,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,929,200.00 | 6,312,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,929,200.00 | 6,312,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,716,400.00 | 25,251,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,971,999.90 | 55,579,809.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,212,587.90 | 1,800,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,304,224.00 | 23,921,809.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 2,358,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 41,455,188.00 | 27,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,051,895.53 | 21,932,082.11 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 19,051,895.53 | 21,932,082.11 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,059,100.00 | 49,218,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,722,100.00 | 41,154,650.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,337,000.00 | 8,063,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **41,765,000.10** | **52,932,551.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 41,564,500.00 | 52,932,360.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,366,200.00 | 52,932,360.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,198,300.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 200,500.10 | 191.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 200,500.10 | 191.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **107,904,348.47** | **(72,818,566.11)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **22,242,300.00** | **20,476,400.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **22,242,300.00** | **20,476,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 22,242,300.00 | 20,476,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 22,242,300.00 | 20,476,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(22,242,300.00)** | **(20,476,400.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 85,662,048.47 | (93,294,966.11) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 20,139,213.47 | 105,801,213.47 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 105,801,213.47 | 12,506,247.36 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | 92,725,970.67 | 92,725,970.67 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **92,725,970.67** | 92,725,970.67 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | 1,423,549,298.81 | 1,423,549,298.81 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **1,516,275,269.48** | 1,516,275,269.48 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **1,516,275,269.48** | 1,516,275,269.48 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **1,516,275,269.48** | 1,516,275,269.48 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 5,200,000.00 | | 5,200,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | -66,287,553.94 | -66,287,553.94 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,200,000.00** | **1,449,987,715.54** | 1,455,187,715.54 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 105,801,213.47 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,652,332,500.00** | **1,616,542,975.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,652,332,500.00 | 1,616,542,975.11 |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,595,798,400.00 | 1,563,610,615.11 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,262,558,500.00 | 1,257,583,974.00 |
| 210101 | Үндсэн цалин | 782,544,000.00 | 742,075,797.00 |
| 210102 | Нэмэгдэл | 437,184,500.00 | 412,237,551.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 40,775,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,830,000.00 | 62,495,626.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 157,819,900.00 | 157,819,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 107,317,500.00 | 107,317,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,625,600.00 | 12,625,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,312,800.00 | 6,312,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,312,800.00 | 6,312,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,251,200.00 | 25,251,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79,580,000.00 | 55,579,809.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47,180,000.00 | 23,921,809.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 2,358,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 27,600,000.00 | 27,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 23,390,600.00 | 23,568,799.18 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,414,700.00 | 1,914,700.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,975,900.00 | 21,654,099.18 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 71,449,400.00 | 68,058,132.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,965,600.00 | 59,574,332.93 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,483,800.00 | 8,483,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,534,100.00 | 52,932,360.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,534,100.00 | 52,932,360.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 56,534,100.00 | 52,932,360.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,652,332,500.00** | **1,523,248,009.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,569,837,800.00 | 1,466,333,200.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,569,837,800.00 | 1,466,333,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 80,580,000.00 | 56,579,809.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 80,580,000.00 | 56,579,809.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,914,700.00 | 335,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,414,700.00 | 335,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 500,000.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 105,801,213.47 |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 12,506,247.36 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 47.00 | 47.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31.00 | 31.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15.00 | 15.00 |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн №09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1,216.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 18.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлсэн байдлыг шалгаж үзэхэд “5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлэх"-ээс 108.9 сая төгрөгийн 6 гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 284.2 сая төгрөгийн 12 гүйлгээг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 32.3 сая төгрөгийн 3 гүйлгээг бүгд 425.4 сая төгрөгийн 21 гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 69.1 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээлээлгүй 425.4 сая төгрөгийн 21 гүйлгээг нөхөж байршуулан зөрчил арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 3 | 0 | 3 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **3** | **0** | **3** | **0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн боловч цаг хугацааны асуудлаар бүрэн шалгах боломжгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 241.1 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн Үр дүнгийн тайланд 26.0 сая төгрөгийн орон нутгийн төсвийн санхүүжилтийг илүү, 56.3 сая төгрөгийн төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг дутуу тусгасан,
- Мөнгөн гүйлгээний тайланд 26.0 сая төгрөгийн орон нутгийн төсвийн санхүүжилтийг илүү, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлгийг 26.0 сая төгрөгөөр илүү тусгасан,

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.3 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1.6 сая төгрөгөөр илүү, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зарлагын төлөвлөгөөг 1,417.4 мянган төгрөгөөр дутуу, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөөний үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих дүнг 103.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 23.2 сая төгрөгийн зөрчил[1] илэрч 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 2.1 сая төгрөгт зөрчил арилгах албан шаардлага, 17.4 сая төгрөгт 2 зөвлөм хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1.Нярвын хүнсний материалын орлого, зарлагын тооцоогоор 50.9 сая төгрөгийн материалын орлого авч, 52.5 сая төгрөгийн материалыг зарцуулсан ба эхний, эцсийн үлдэгдлийг тайландаа тусгаагүй байна. Санхүүгийн тайлангаар бараа материалын тодруулга тайланд хүнсний материалын дансны оны эхний үлдэгдэл 2.1 сая төгрөг ба 54.5 сая төгрөгийн материалын орлого, 56.3 сая төгрөгийн зарцуулан, 0.3 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнасан. Гэтэл бараа материалын тодруулга тайлангийн орлого 3.6 сая төгрөгөөр, зарлага нь 3.7 сая төгрөгөөр нярвын тайлангийн орлого, зарлагаас тус тус илүү байна. Хоолны зардлаас хүнсний материалын үнэд шилжүүлсэн 3.6 сая төгрөгийн материалыг нярав орлогод аваагүй, нярав нь бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, нягтлан бодогч нь сар бүр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулан ажиллаагүй байна. Нярвын тайланд 3.6 сая төгрөгийн материалыг оруулж тооцоо хийхэд, хоолны зардлаас 3.7 сая төгрөгийн материалыг зарцуулалтын анхан шатны баримтгүй санхүүгийн тайланд тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6. "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс хүнсний зардлаас анхан шатны баримтгүй зарцуулсан 3.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар 2.1 сая төгрөгийн албан шаардлага өгөгдөв.

1.Сургуулийн захирал нь тайлант онд үр дүнгийн урамшууллыг нягтлан бодогч, нярав болон бусад албан хаагч нарт мөнгөн урамшуулал олгох журмын дагуу олгож ирсэн боловч 2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр "Урамшуулал олгох тухай" Б/30 тоот тушаалаар 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгээр “Өөрчлөлтгүй” гэж дүгнэгдсэн нягтлан бодогч, нярав нарт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг 2,121.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

_Шийдвэрлэсэн нь_: Төсвөөс холбогдох хууль, журам зөрчиж олгосон 2,121.9 мянган төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитаар 17.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв.

***1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***1.1. Илрүүлэлт:***

Сургуулийн нярвын тайланд бараа материалын эхний, эцсийн үлдэгдлийг сар бүр гаргаж баталгаажуулаагүй, хүнсний материалын 4 удаагийн 17.4 сая төгрөгийн худалдан авалтын орлогыг бараа материалын дэлгэрэнгүй журналд бөөн дүнгээр орлого, зарлагад бүртгэж тайлагнасан байна.

***1.2 Өгсөн зөвлөмж:***

Нярвын тайланд бараа материалын эхний, эцсийн үлдэгдлийг сар бүр гаргаж баталгаажуулах, бараа материалын дэлгэрэнгүй журналд хүнсний материалын орлого, зарлагыг дэлгэрэнгүй бүртгэж тайлагнах;

***2.1. Илрүүлэлт:***

Сургуулийн захирлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/18 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комисс томилсон боловч санхүүгийн тайланд тусгагдсан, бараа материалын материалын үлдэгдлийг бодитой тоолж, тооцоог бодоогүй тооллогыг зохих журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.

***2.2 Өгсөн зөвлөмж:***

Бараа материалын тооллогыг санхүүгийн тайлан гарахаас өмнө хагас, бүтэн жилээр 2 удаа хийж, үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг хэрэгжүүлж ажиллах.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар*

*сарын 01-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СТҮД-ийн тайлан, МГТ-ийн тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 134,296.9 | | | 1 | 134,296.9 | 1 | 134,296.9 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан | 1 | 106,836.6 | | | 1 | 106,836.6 | 1 | 106,836.6 | | | | |
| **Дүн** | 2 | **241,133.5** | | | **2** | **241,133.5** | **2** | **241,133.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мөнгөн урамшуулал илүү олгосон | 1 | 2,121.9 | | | 1 | 2,122.0 | | | | | | |
| Хоолны зардлыг дутаасан | 1 | 3,737.9 | 1 | 3,737.9 | | | | | | | | |
| Хүнсний орлого, зарлагыг бөөн дүнгээр авч, бөөн дүнгээр гаргасан | 1 | 17,387.7 | | | | | 1 | 17,387.7 | | | | |
| Жилийн эцэст ҮХ, БМ-ын тооллогын зохих журмын дагуу хийгээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | 4 | 23,247.5 | 1 | 3,737.9 | 1 | 2,122.0 | 2 | 17,387.7 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй хэрэгжилт 69.1 хувьтай. | 1 | 425,442.8 | | | 1 | 425,442.8 | | |
| Дүн | **1** | **425,442.8** | | | **1** | **425,442.8** | | |
| Засгийн газрын тогтоол, сайдын тушаалтай холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |